



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Ж.БАТТӨРД

2017.01.23

№

04

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад 2016 оны 09-р сард 250,0 мянган төгрөгийн шатахуун баримтгүйгээр зарцуулсан ба 12-р сарын шатахууны үлдэгдэл 84,7 мянган төгрөгөөр дутагдаж байна.

Энэ нь нярвын шатахууны тайланг тулган шалгаж хүлээн аваагүйгээс шалтгаалжээ.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

516716

1. Дээрх дутагдсан 334,7 мянган төгрөгийн шатахууны үнийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь Хүү, торгуулийн орлогын 030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017.03.01-ний дотор Баянхонгор аймгийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ХХААГазрын дарга Ж.Баттөр , Нягтлан бодогч Т.Цэрэндолгор нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

Ахлах аудитор

Б.Мөнхбат

ЗӨВШӨӨРСӨН:

Дарга

Ж.Баттөр

Ня-бо

Т.Цэрэндолгор

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гараасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Н.БАТТОГТОХ-д

2017.02.09

№

27

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорилоор эмийн бэлтгэн нийлүүлэгч АйВиКо ХХК-нд илүү шилжүүлсэн 5314,8 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. АйВиКо ХХК-нд илүү шилжүүлсэн 5314,8 мянган төгрөгийг тус компанийн 2017 оны 1-р сарын тооцооноос суутган Төрийн сан банк дахь бусад төлбөр хураамжийн 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

516339

Хоёр. Төлбөрийн актыг барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 02 дугаар сарын 16-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал нарт хариуцуулав.

	АКТЫГ ТОГТООСОН:	
АХЛАХ АУДИТОР		Б.МӨНХБАТ
	АКТЫГ ЗӨВШӨӨРСӨН:	
ДАРГА		Н.БАТТОГТОХ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ		Ж.БАТЖАРГАЛ

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаа хувацанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Д.БЯМБАСҮРЭН-Д

2016.12.03

№

01

Төлбөр барагдуулах тухай

Нэгдсэн эмнэлгийн 2016 оны 3-р улирлын санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэгдсэн эмнэлгийн бэлэн мөнгөний орлогын 2016.12.23-ны өдрийн касс, жижиг мөнгөн сангийн гүйлгээ, үлдэгдэлд тооллого хийхэд 7,0 сая төгрөгийн дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 276 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-н 2.6-д "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч болно. Энэхүү орлогыг хүлээн авсан тохиолдолд төсвийн байгууллага түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд дараагийн ажлын өдөртөө багтаан өөрийн Төрийн сангийн бүртгэлийн дансанд шилжүүлнэ." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.4 дахь "Тооллогоор мөнгөн хөрөнгө дутагдсан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Кассын дутагдал 7,0 сая төгрөгийг нярав Ариунжаргалаар төлүүлэх.

Хоёр. Төлбөрийг 2016 оны 12 дугаар сарын 26-ны дотор төлүүлэн Төрийн сан банкин дахь Хүү торгуулийн орлогын 030000947 тоот дансанд оруулахыг Нэгдсэн

516013

эмнэлгийн дарга Д.Бямбасүрэн, ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

АКТЫГ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА



Д.БЯМБАСҮРЭН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Ж.БАТЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлын биелэлт хангавдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 28.2-д зөвсөн "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харуулагч албан тушаалтанд харууллага нэгдүгээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-64
E-mail: bayankhongor@audit.gov.mn

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Д.БЯМБАСҮРЭН-д

2016.12.23

№

03

Төлбөр барагдуулах тухай

Нэгдсэн эмнэлгийн 2016 оны 3-р улирлын санхүүгийн тайланд зарсарын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Ажиллагсдад олгосон хоолны үнэ 9,0 сая төгрөгийг хүнсний зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Ажиллагсдад олгосон хоолны үнэ 9,0 сая төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх.

516715

Хоёр. Төлбөрийг 2016 оны 12 дугаар сарын 26-ны дотор төлүүлэн Төрийн сан
банкин дахь Хүү торгуулийн орлогын 030000947 тоот дансанд оруулахыг Нэгдсэн
эмнэлгийн дарга Д.Бямбасүрэн, ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал нарт
хариуцуулав.

АКТЫГ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АКТЫГ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

Д.БЯМБАСҮРЭН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ж.БАТЖАРГАЛ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангавдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2016.12.28

№

02

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГА Д.БЯМБАСҮРЭН-д

Төлбөр барагдуулах тухай

Нэгдсэн эмнэлгийн 2016 оны 3-р улирлын санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлыг зориулалт бусаар зарцуулж 3.9 сая төгрөгөөр тэмцээн уралдаанд оролцох зорилгоор эмч, ажилтнуудад биеийн тамирын хувцас авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Зориулалт бусаар зарцуулсан 3,9 сая төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх.

516914

Хоёр. Төлбөрийг 2016 оны 12 дугаар сарын 26-ны дотор төлүүлэн Төрийн сан
банкин дахь Хүү торгуулийн орлогын 030000947 тоот дансанд оруулахыг Нэгдсэн
эмнэлгийн дарга Д.Бямбасүрэн, ерөнхий нягтлан бодогч Ж.Батжаргал нарт
хариуцуулав.

АКТЫГ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АКТЫГ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

Д.БЯМБАСҮРЭН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ж.БАТЖАРГАЛ

¹ Акт, албан шаварлалсын биетэлт хөтөөгдөөгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас төгссөн албан шаварлалаа, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэхгүй тохиолдолд зөрчил зараасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллагаар эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлжээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯНХОНГОР АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

АКТ

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ГАЛУУТ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭГМИД-д

2017.02.15 № 40

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад 2016 оны 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 сарын 16 өдөр Дугаар 362/112/183 тоот тушаалын 2-р хавсралт "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" –н дагуу багш, ажилчдын ажлыг нь үнэлэлгүй, нийтэд нь 25 хувийн ур чадварын нэмэгдэл олгох тухай байгууллагын даргын тушаал гарган 1917,3 мянган төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 1995 оны 96-р тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам"-ын 4-р хавсралт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 сарын 16 өдөр Дугаар 362/112/183 тоот тушаалын "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт" гэсэн 2-р хавсралтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дэх "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "Улсад

516352

болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Зориулалт бусаар зарцуулсан 1917,3 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад төлбөр хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

Хоёр. Төлбөрийн актыг барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 05 дугаар сарын 16-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Галуут сумын Сургуулийн захирал С.Цэгмид, нягтлан бодогч С.Ариунжаргал нарт хариуцуулав.



АКТЫГ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

АКТЫГ ЗӨВШӨӨРСӨН:

ДАРГА

С.ЦЭГМИД

НЯГТЛАН БОДОГЧ

A handwritten signature in black ink, likely belonging to S. Ariunjaragal.

С.АРИУНЖАРГАЛ

¹ Акт, албан шаварлалтын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас төвөгсөн албан шаварлалад, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зарчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны бөгөөд хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.